БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА С.БАТ-ОРГИЛ

2026 оны .... дугаар сарын ....-ны өдөр

# ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН
ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ДЭД ХУРАНДАА Л.ДОРЖДЭРЭМ

БОЛОВСРУУЛСАН
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА ........................ Д.АДИЛБИШ

ШАРХУЛСАН
2026 ОН

**ЗАГВАР**

## ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

| № | Төлөвлөгөөг тодотгосон албан тушаалтан, овог нэр | Тодотгол хийсэн он, сар, өдөр | Хуудасны дугаар | Мөрийн дугаар | Тодотгол хийсэн товч утга |
|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | |
| 2. | | | | | |
| 3. | | | | | |
| 4. | | | | | |
| 5. | | | | | |
| 6. | | | | | |
| 7. | | | | | |
| 8. | | | | | |
| 9. | | | | | |
| 10. | | | | | |
| 11. | | | | | |
| 12. | | | | | |
| 13. | | | | | |
| 14. | | | | | |
| 15. | | | | | |
| 16. | | | | | |
| 17. | | | | | |
| 18. | | | | | |

**ЗАГВАР**

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
1.1.Төлөвлөгөөний үндэслэл
1.2. Зорилго
1.3. Зорилт
1.4. Зарчим
1.5. Хамрах хүрээ
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
2.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах.
2.3. Гамшгаас хамгаалах сургалт.
ГУРАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ
3.2. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын бүтэц
3.3 Гамшгийн үеийн удирдлага зохицуулалт
ДӨРӨВ. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ:
4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг байгууллагуудад дамжуулах:
4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах:
ТАВ. ГАМШГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ
5.1. Гамшгийн нийтлэг хариу арга хэмжээ, удирдлага зохицуулалт:
5.2. Байгууллагуудын түвшинд авч хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээ:
5.3 Газар хөдлөлтийн гамшгийн хариу арга хэмжээ
5.4 Үерийн хариу арга хэмжээ
5.5 ал түймрийн гамшгийн хариу арга хэмжээ
5.6 Хүчтэй салхи, шуурганы гамшгийн хариу арга хэмжээ
5.7 Зудын гамшгийн хариу арга хэмжээ
5.8.Уул уурхайн ослын хариу арга хэмжээ
5.9. Химийн ослын хариу арга хэмжээ
ЗУРГАА. ХАНГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
ДОЛОО. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ
НАЙМ. ХҮЧ ХЭРЭГСЭЛ ДАЙЧЛАН ГАРГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
8.1.Хүч хэрэгсэл дайчлан гаргах үйл ажиллагааны удирдлага зохицуулалт
8.2. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө
ЕС. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ
9.1. Хүмүүнлэгийн тусламжийн удирдлага зохицуулалт
9.2. Орон нутгийн нөөцийн зохион байгуулалтын арга хэмжээ
9.3. Дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах арга хэмжээ
АРВАН. ТӨСӨВ, САНХҮҮ
АРВАН НЭГ. БУСАД

ХАВСРАЛТ

- Сумын танилцуулга
- Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээний тойм судалгаа /эрсдэлийн үр дүнг оруулах/
- Зарлан мэдээлэл дамжуулах схем
- Зарлан мэдээллийн дууд дохионы судалгаа
- Онцгой комиссыг томилсон захирамж
- Шуурхай штаб байгуулах тухай захирамжийн төсөл
- Бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, цуцлах тухай захирамжийн төсөл
- Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай захирамжийн төсөл
- Хүч хэрэгсэл дайчлан гаргах захирамжийн тухай төсөл
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн судалгаа
- Дайчлан ажиллуулах хүн хүчний судалгаа
- Дайчлан ажиллуулах техникийн судалгаа
- Дайчлан ажиллуулах багаж, хэрэгсэл тоног төхөөрөмжийн судалгаа
- Дайчлан ажиллуулах барилга байгууламжийн судалгаа
- Дайчлан ажиллуулах өмч хөрөнгийн судалгаа
- Түр цугларах талбайн судалгаа, зураглал
- Түр орон байрны судалгаа
- Нисдэг тэрэг буух талбайн байршил, зураглал
- Нүүлгэн шилжүүлэх талбайн байршил, зураглал
- Гамшгийн болон орон нутгийн нөөцийн судалгаа
- Нийгмийн хариуцлагын гэрээ
- Сайн дурын хэсэг томилсон шийдвэр

**ЗАГВАР**

## Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

**1.1.Үндэслэл:** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”, 32 дугаар зүйлийн 32.1.1 Засаг даргын бүрэн эрхэд “Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус хэрэгжүүлнэ.

**1.2. Зорилго:** Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдлага зохицуулалтаар хангахад оршино.

**1.3. Зорилт**

1.3.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах
1.3.2. Сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах;
1.3.3. Гамшгийн хариу арга хэмжээг шуурхай нэгдсэн удирдлагатай зохион байгуулах;
1.3.4. Хойшлуулшгүй сэргээн босгох;
1.3.5. Хүч хэрэгсэл дайчлан гаргах;
1.3.6. Нүүлгэн шилжүүлэх;
1.3.7. Хүмүүнлэгийн тусламж зохион байгуулах.

**1.4. Зарчим**

1.4.1. Шуурхай;
1.4.2. Тасралтгүй;
1.4.3. Нэгдсэн;
1.4.4. Ил тод.

**1.5. Хамрах хүрээ**

1.5.1. Энэхүү төлөвлөгөөг Дундговь аймгийн Сайнцагаан сумын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд Сумын онцгой комисс, шуурхай штаб, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, захиргаа болон бүх шатны аж ахуй, нэгж байгууллага, сайн дурын хэсэг, иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ

**3.1.1. Тактикийн түвшин (Сумын ОК):**

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, хэрэгжүүлэх;
- Сумын онцгой комиссын Шуурхай штабыг холбогдох журмын дагуу байгуулж, гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах;
- Улсын болон аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэр, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэх;
- Шуурхай штабыг байгуулж, гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, шуурхай бүлгийн бэлэн байдлыг хангах;

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг бодит мэдээ, мэдээллээр хангаж, шийдвэрлүүлэх асуудлыг тухай бүр нь танилцуулах;

## Хоёрдугаар бүлэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

### 2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

**1. Сайнцагаан сумын үерийн аюулын мужийн зураглал**




Сайнцагаан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үерийн эрсдэлийн түвшнийг тодорхойлоход аюулын индекс 3.0, эмзэг байдлын индекс 3.0, өртөх байдлын индекс 3.5, чадавхын индекс 3.2 байна.

Аргачлалын дагуу аюул, эмзэг байдал, өртөх байдлын индексийн нэмэгдэхүүнээс чадавхын индексийг хасахад тус аймагт үерийн эрсдэлийн түвшин "Дунд" буюу 3.25%-тай үнэлэгдэв.

**2. Хүчтэй цасан болон шороон шуурганы аюулын мужийн зураглал**




Хүчтэй цасан болон шороон шуурганы эрсдэлийн үнэлгээгээр аюул, өртөнгө байдал тус тус 4.0, эмзэг байдал 3.2, чадавх 3.7 оноотой, эрдэлийн түвшин буюу Дунд түвшинд үнэлэгдсэн.

### 3. Сайнцагаан сумын газар хөдлөлтийн аюулын мужийн зураглал





Газар хөдлөлтийн эрсдэлийн аюулын түвшин тухайн аймгийн нутаг дэвсгэрийн 1595.8 км2 нь **Дунд,** 21.465.8 км2 **Их,** 51.632.6 км2 нь **Маш их** түвшинд байна.

### 2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| **Сумын Засаг дарга бөгөөд онцгой комиссын дарга** | | | | |
| 1. | Сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, Засаг даргын мөрийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах арга хэмжээг тусгах | 12 сард | ЗДТГ | ИТХ |
| | Далан, суваг шуудуу, инженерийн бэлтгэл арга хэмжээг нарийвчлан төлөвлөх, хэрэгжүүлэх | 1, 2 дугаар улирад | Сумын Онцгой комисс | Газрын даамал |
| | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх | Тухай бүр | ЗДТГ | ИТХ |
| | Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах | Тухай бүр | Тамгын газрын дарга | Зарлан мэдээллийн бүлэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх | Тухай бүр | ЗДТГ | Санхүү зохицуулалтын бүлэг |
| | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохгүй байх | Тухай бүр | ЗДТГ | Газрын даамал |
| | Сумын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах | Тухай бүр | Тамгын газрын дарга | Мэдээлэл сурталчилгаан ы бүлэг |
| | Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, түр цугларах талбай, түр байрыг томилгоожуулах, бэлтгэх, газрыг баталгаажуулалтад хяналт тавих | Тухай бүр | Тамгын газрын дарга | Нүүлгэн шилжүүлэх бүлэг |
| | Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгаа гаргах, холбогдох газарт хүргүүлэх; | Тухай бүр | Тамгын газрын дарга | Хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах бүлэг |
| | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | | | |
| | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т заасан нөөц төсөв болон гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг батлах, хэрэгжилтийг хангах. | I,IV улирал | ИТХ | ЗДТГ |
| | Сумын Засаг дарга болон Онцгой комиссоос гаргасан гамшгийн бэлэн байдлын шийдвэрүүд, хөдөлгөөний хязгаарлалт, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд төлөөлөгчийн чиг үүргийн дагуу хяналт тавьж, иргэдийн эрх ашгийг хамгаалах. | Тухай бүр | Иргэдийн төлөөлөгч | Мал эмнэлэгийн тасаг |
| | Түлш, эрчим хүчний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах, нөөц эх үүсвэрийг бэлэн байлгах | Тухай бүр | ИТХ | Хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах бүлэг |
| | Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн нөлөөллийн үнэлгээг тухай бүр хийх, урьдчилсан мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх | Тухай бүр | Мэдээлэл сурталчилга аны бүлэг | Цаг уурын өртөө |
| | Сум дундын эмнэлэг | | | |
| | Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах; | Тухай бүр | Сум дундын эмнэлэг | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүлэг |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; | Тухай бүр | Сум дундын эмнэлэг | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүлэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг тухай бүрт үнэлж, зөвлөмж боловсруулж сумын онцгой комисст танилцуулах; | Тухай бүр | Сум дундын эмнэлэг | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүлэг |
| | Гамшгийн үед нэрвэгдэгсэд болон хүний гоц халдварт өвчнөөр өвчилсөн иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хээрийн эмнэлэг дэлгэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүнээр хангах нөөц бүрдүүлэх; | Тухай бүр | Сум дундын эмнэлэг | Хээрийн эмнэлэг дэлгэх хэсэг |
| | Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, багц мессежээр урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэх; | Тухай бүр | Сум дундын эмнэлэг | Мэдээлэл сурталчилгаан ы бүлэг |
| | Цагдаагийн хэсэг | | | |
| | Гамшиг, ослын голомт болон хорио цээрийн бүсэд хамгаалалт зохион байгуулах бэлтгэлийг хангуулах; | Тухай бүр | Цагдаагийн хэсэг | Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бүлэг |
| | Тэсэрч дэлбэрэх бодисын хууль бус хэрэглээтэй холбоотой асуудлыг мөрдөн шалгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; | Тухай бүр | Цагдаагийн хэсэг | Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бүлэг |
| | Гамшгийн үед эргүүл, хяналтыг гарган аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, арга хэмжээг урьдчилан төлөвлөх. | Тухай бүр | Цагдаагийн хэсэг | Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бүлэг |
| | Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | | | |
| | Сургууль, цэцэрлэгийн гадна, дотно аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; | Тухай бүр | Сургуулийн захиргаа | Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг |
| | Гамшгийн үед түр орон байраар ашиглах байрны бэлэн байдлыг хангуулах, холбогдох мэдээллийг гаргах; | Тухай бүр | Тамгын газрын дарга | Нүүлгэн шилжүүлэх бүлэг |
| | Суралцагчдад гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг насны ангилалд тохируулан сургалтын хөтөлбөрт тусгах, үр дүнтэй зохион байгуулах, гамшгаас хамгаалах дадлага сургуулийг зохион байгуулах; | Тухай бүр | Сургуулийн захиргаа | Мэдээлэл сурталчилгаан ы бүлэг |
| | Сумын хэмжээний боловсролын байгууллагад суралцаж буй тусгай хэрэгцээт хүүхдүүдийн судалгааг гаргах. | Тухай бүр | Нийгмийн ажилтан | Засаг даргын тамгын газрын халамж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | үйлчилгээний мэргэжилтэн |
| Бусад хуулийн этгээд | | | | |
| | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх; | I, IV улиралд | Удирдлага | Нягтлан |
| | Байгууллагын аюулгүй байдлыг тогтмол шалгах, энэ чиглэлээр холбогдох албан тушаалтны томилох; | Тухай бүр | Удирдлага | Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсэг |
| | Байгууллагын гал түймэр, гамшгийн аюулгүй байдлыг хангах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах; | Тухай бүр | Удирдлага | Гал түймэр унтраах, аврах хэсэг |
| | Гамшгийн үед байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх; | Тухай бүр | Удирдлага | Тамгын газрын дарга |
| | Ерөнхий мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулах сургаж дадлагажуулах, холбогдох байгууллагатай мэдээ мэдэлэл солилцох. | Тухай бүр | Удирдлага | Тамгын газрын дарга |

## 2.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах:

3.1. Энэ төлөвлөгөөг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны аж ахуйн нэгж байгууллагууд бэлэн байдлыг хангах дараах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ: /ГХТХ-н 37.2 дэхь хэсэг, 2024.11.01-ний өдрийн А/379 дүгээр тушаал/

| № | Бэлэн байдлыг хангах арга хэмжээ | Хугацаа | Удирдлага зохион байгуулалт | Хэрэгжүүлэх албан тушаалтан | Дэмжлэг үзүүлэх ерөний зориулалтын мэргэжлийн анги |
|---|---|---|---|---|---|
| Нэг. Удирдлага зохион байгуулалтаар хангах | | | | | |
| 1.1 | Гамшгийн үед албан байгууллагуудын хамтран ажиллах улдаа, холбоог хангах төлөвлөгөөг боловсруулж батлуулах; | Жил бүр | Сумын ОК | Сумын ЗДТГ-ын дарга | Байгууллагын удирдлагууд |
| 1.2 | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын хангах, үзлэг явуулах, үнэлэх журам” А/383 дугаар тушаалын хэрэгжилт, биелэлтийг хангуулах, үнэлж дүгнэх; (Бэлэн байдлыг Онцгой байдлын байгууллагаас үнэлж дүгнэнэ) | Тухай бүр | Аймгийн Онцгой байдлын газар, Сумын ЗДТГ | Сумын ЗДТГ-ын дарга | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги |
| 1.3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх; | Жил бүр | Аймгийн Онцгой байдлын газар, | Сумын ЗДТГ-ын дарга | Багийн ЗД нар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Сумын ЗДТГ | | |
| | Хоёр. Хүн хүч, тенхик хэрэгсэл, нөөц бүрдүүлэх | | | | |
| 2.1 | Гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах томилгоот хүч хэрэгсэл (хүн, техник, багаж, тоног төхөөрөмж, зэвсэглэмж, хамгаалах хэрэгсэл)-ийн судалгааг гаргах, тодотгох, нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, тэдгээрийг дайчлан ашиглах боломжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах; | Жилд 1 удаа | Сумын ОК, ШШ | Сумын ЗДТГ-ын дарга | Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги |
| 2.2 | Гамшгийн үед сумын төсвөөс санхүү, хөрөнгө гаргах, зохицуулалт хийх, зохион байгуулах | Тухай бүр | Сумын ОК | ЗДТГ-ын дарга | Санхүү зохицуулалтын бүлэг |
| 2.3 | Гамшгийн үед байгууллагад ашиглагдах бүх төрлийн нөөц (хүнс, шатах тослох материал, бараа материал, бусад) бүрдүүлэх, нэмэгдүүлэх; | Тухай бүр | Сумын ОК | Байгууллагын удирдлагууд | Санхүү зохицуулалтын бүлэг |
| 2.4 | Ажилтан, алба хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, хээрийн үүргэвчээр хангах; | Тухай бүр | Сумын ОК | Сумдын Засаг дарга нар | Санхүү зохицуулалтын бүлэг |
| 2.5 | Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулах шаардлагатай хүн, хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, тодотгох, зам маршрутыг тодорхойлох, | Жилд 1 удаа | Сумын ОК | Сумын ЗДТГ-ын дарга | Нүүлгэн шилжүүлэх бүлэг |
| 2.6 | Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлтийн талбайг тогтоох, иргэдэд таниулах | Жилд 1 удаа | Сумын ЗДТГ | Сумын ЗДТГ-ын дарга | Нүүлгэн шилжүүлэх бүлэг |
| Гурав. Сургалт, дадлага зохион байгуулах, чадавхижуулах | | | | | |
| 3.1 | Сумдын удирдах бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах талаарх хууль эрх зүйн мэдлэг болон гамшгийн үед шийдвэр гаргах чадвар эзэмших; | Жил бүр | Сумын ОК | ОБГ<br>Сумын ЗДТГ-ын дарга | Сайн дурын хэсэг |
| 3.2 | Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн томилгоог тодотгож, гамшгийн үед холбогдох хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чадвар эзэмших; | Жилд 1 удаа | ОБГ,<br>СЗДТГ | Сумын ЗДТГ-ын дарга | Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.3 | Ажилтан, алба хаагч нарыг гамшгийн үед ажиллах шуурхай штаб, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, бүлэг, хэсгүүдийг томилгоожуулж, сургаж дадлагажуулах; | Жилд 1 удаа | Сумын ЗДТГ | ОБГ, Сайн дурын хэсэг | Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги |
| Дөрөв. Холбоо зохион байгуулалтын бэлэн байдлыг хангах | | | | | |
| 4.1 | Гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах, дохиогоор түргэн цугларах дадлага сургууль зохион байгуулах; | Жилд 1 удаа | Сумын ОК | Сумын ЗДТГ-ын дарга | Зарлан мэдээллийн бүлэг |
| .4.2 | Гамшиг, ослын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах, гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах мэдлэг ойлголтыг олгох | Жилд 1 удаа | СОК-ын дарга | Сумын ЗДТГ-ын дарга | Мэдээлэл, сурталчилгааны бүлэг |

2.2.2. Гамшгийн үед тухайн сумын Онцгой комисс, Сумын Засаг даргын Тамгын газраас заасан хугацаанд томилгоот хүч хэрэгслийг бэлэн байлгах, техник, багаж хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах үүргийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага хүлээнэ.

2.2.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам”-ын дагуу сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагын бэлэн байдлыг аймгийн Онцгой байдлын байгууллагаас үнэлж дүгнэнэ.

## 2.3. Гамшгаас хамгаалах сургалт:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3, 13.2.4, 13.2.5, 13.2.6 дэх хэсэгт заасны дагуу дараах байдлаар зохион байгуулна.

Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн сургалтыг улирал бүр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Сайн дурын хэсгийн сургалтыг жилд 2-оос доошгүй удаа Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, иргэдийн сургалтыг жилд 2-оос доошгүй удаа багийн Засаг дарга, сурагчдын сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал сар бүр тус тус хариуцан зохион байгуулна.

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцан албан тушаалтан | Дэмжлэг үзүүлэх байгууллага | Төсөв |
|---|---|---|---|---|---|
| 1.1 | Удирдах бүрэлдэхүүний сургалт | Жилд 2 удаа | Засаг дарга | ОБГ | Орон нутгийн төсөв |
| 1.2 | Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулах | Улирал бүр | Мэргэжлийн ангийн дарга | ОБГ | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.3 | Сумын иргэдийг сургаж, дадлагажуулах | Жилд 2-доошгүй удаа | Багийн Засаг дарга | сумын ЗДТГ | - |
| 1.4 | Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг сургаж дадлагажуулах | Жилд 2-доошгүй удаа | Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга | УЗХ | Орон нутгийн төсөв |
| 1.5 | Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг сургаж дадлагажуулах | Жилд 2-доошгүй удаа | Сумын Засаг даргын Тамгын газрын дарга | ОБГ | Орон нутгийн төсөв |
| 1.6 | Ерөнхий боловсролын сургууль, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Улирал бүр | Цэцэрлэгийн эрхлэгч, Ерөнхий боловсролын сургуулийн захирал | Сумын Засаг даргын Тамгын газрын дарга | Орон нутгийн төсөв |
| 1.7 | МУ-ын Засгийн газрын 2011 оны 339 дугаар тогтоолын хүрээнд сургалт, дадлагад хамрагдах | 3 дугаар сарын сүүлийн 7 хоногийн пүрэв гараг | Мэргэжлийн ангийн дарга | Мэргэжлийн ангийн бүлэг, хэсгүүд | Орон нутгийн төсөв |

**2.3.1** Сургалт зохион байгуулсан тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, сумын онцгой комисст танилцуулна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ

### 3.1.1. Тактикийн түвшин (Сумын ОК):

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, хэрэгжүүлэх;
- Гамшгийн үед сумын онцгой комиссын Шуурхай штабыг холбогдох журмын дагуу байгуулж, гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах;
- Улсын болон аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэр, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэх;
- Шуурхай штабыг байгуулж, гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, шуурхай бүлгийн бэлэн байдлыг хангах;
- Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг бодит мэдээ, мэдээллээр хангаж, шийдвэрлүүлэх асуудлыг тухай бүр нь танилцуулах;
- Сумын мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Дээд шатнаас гарсан шийдвэрийг иргэдэд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах;
- Иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй үзүүлж, аюулгүй байдлыг хангуулж ажиллах;
- Улсын болон орон нутгийн нөөц болон хүмүүнлэгийн тусламж хүсэх, холбогдох тооцоо, судалгаа гаргаж, аймаг, нийслэлийн Онцгой комисст хүргүүлж, хуваарилсан нөөцийг үр дүнтэй зарцуулж, хяналт тавьж, тайлагнах;
- Иргэн, хуулийн этгээдийг дайчлан гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Дэд бүтцийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг хангах, аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;

### 3.2. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын бүтэц

**ЗАГВАР**




**3.3 Гамшгийн үеийн удирдлага зохицуулалт**

3.3.1. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг удирдлага болгон сумын Онцгой комиссын шуурхай штабыг Онцгой комиссын даргын шийдвэрээр гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг түшиглэн байгуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 152 дугаар тогтоолын 1.3-т заасны дагуу сумын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны Засаг дарга батална.

| д/д | Аюулт үзэгдэл ослын төрөл | Удирдан зохицуулах алба, байгууллага | Дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах бүлэг, байгууллага |
|---|---|---|---|
| 1 | Газар хөдлөлт | Сумын онцгой комисс | Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг |
| 2 | Хүчтэй цасан болон шороон шуурга | | Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг |
| 3 | Хээрийн түймэр | | Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг |
| 4 | Малын гоц халдварт өвчин | | Мал эмнэлгийн бүлэг |
| 5 | Зуд | | Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг |

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

4.1 Сумын нутаг дэвсгэрт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага, мэдээг сумын Засаг даргад танилцуулж, Онцгой байдлын байгууллагад мэдээлнэ.

4.2 Сумын нутаг дэвсгэрт үүссэн болон үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн сумын Засаг даргын шийдвэрээр зарлан мэдээллийн бүх хэрэгслээр дамжуулна. /МУ-ын ЗГ-ын 339 тогтоолын 4.3.1/

4.3 Сумын хэмжээнд зарлан мэдээллийн Сирен дуут дохиог байнгын бэлэн байдалд байлгаж, чухал шаардлагатай тоног төхөөрөмжийн нөөц /сүлжээ үүсгэгч /-ийг бүрдүүлэх. /МУ-ын ЗГ-ын 339 тогтоолын 4.2/

## Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг дамжуулах бүдүүвч

**Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах:**

4.2.1. гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийн тухай анхааруулах бүдүүвч:




Гамшгийн зарлан мэдээллийн дохион дамжуулах бүдүүвч /хүснэгт/-ийн дагуу серень дохио дуугаргана.

| д/д | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хариуцах нэгж | Хүч хэрэгсэл |
|---|---|---|---|---|
| 1 | Зарлан мэдээлэл хүргэх | Сумын ЗДТГ дээвэр дээрхи байрлах серень дохиог ажиллуулах | ЗДТГ-ын жижүүр | Серень дохио 1 ш |
| 2 | | ОБГ дээр байрлах серень дохиог ажиллуулах | ГТУАА-ын дуудлага хүлээн авагч | Серень дохио 1 ш |
| 3 | Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад мэдээллэх | Гамшгийн аюулын мэдээлэл | Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн дарга | Харилцаа холбооны бүх хэрэгслээр |

Мэргэжлийн ангийн дарга болон холбогдох удирдах албан тушаалтны шийдвэрээр бие бүрэлдэхүүнийг гамшиг, осол үүссэн үед "Цуглар", гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуулийн үед "Яаралтай цуглар" дохио өгч ажиллуулна.

Сумын хэмжээнд Онцгой комиссын даргын шийдвэрээр улаан, улбар шар, шар түвшний зарлан мэдээллийг зохион байгуулна.

"Улаан" түвшин нь гамшгийн нөхцөл байдал үүсэж хүн амд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх, аюулгүй газарт шилжин очихыг мэдэгдэж буй хэлбэр:

"Улбар шар" түвшин нь гамшгийн онцгой нөхцөл байдал үүсэж хүн амд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авахыг мэдэгдэж буй хэлбэр:

"Шар" түвшин нь аюултай нөхцөл байдал үүсэж хүн амд аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авахыг мэдэгдэж буй хэлбэр

Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж батлуулах, тухай бүр тодотгох, бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшүүлэх;

## ТАВ. ГАМШГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Сумын Онцгой комисс нь гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд сумын хэмжээний бүх хүч хэрэгслийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн нөхцөл байдал үүссэн үед удирдлагын бичиг баримт болгон хэрэгжүүлнэ.




Газар хөдлөлтийн эрсдэлийн аюулын түвшин тухайн сумын нутаг дэвсгэрийн 3,351.4 км2 нь **Маш их** түвшинд байна. Нийт 1819 байр, нийтийн байр, байшин, гэр маш их эрсдэлтэй түвшинд байна.

**5.1 Газар хөдлөлтийн үеийн хариу арга хэмжээ**

| д/д | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран ажиллах, удирдан зохион байгуулах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зарлан мэдээлэл хүргэх | Серень дохиог ажиллуулах | Ц+00:05 | Сумын Засаг даргын Тамгын газрын жижүүр | ОБГ |
| 2 | | Биет холбоочноор мэдээ хүргүүлэх | Ц+01:00 | Хэвлэл мэдээллийн ажилтан | Сумын Засаг дарга |
| 3 | Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад мэдээллэх | Газар хөдлөлт болсон тухай мэдээлэл өгөх | Ц+00:10 | ЕЗМА-ийн дарга | ОБГ |
| 4 | Онцгой комиссын гишүүд, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг цуглуулах | СӨК-ын бүрэлдэхүүнийг бүртгэх | Ц+00:30 | ЕЗМА-ийн дарга | Сумын Засаг дарга |
| 5 | Онцгой комиссын гишүүдэд мэдээлэл дамжуулах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхжүүлнэ | Ц+00:30-аас | ЕЗМА-ийн дарга | СӨК |
| 6 | Шуурхай үнэлгээ хийх | Харилцаа холбоо тасраагүй тохиолдолд иргэдээс дуудлага мэдээллийг хүлээн авна | Ц+00:30-аас | СӨК | Сумын ЗДТГ-ын дарга |
| 7 | | Тандалтын бүлэг томилж, биетээр мэдээлэл цуглуулах | Ц+00:30-аас | ЕЗМА | Сумын Засаг дарга |
| 8 | | Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр нөхцөл байдлыг тандах | Ц+00:20-аас | СӨК | ОБГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Онцгой комиссыг яаралтай хуралдуулах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхижүүлэх | Ц+00:30-аас | ЕЗМА-ийн дарга | СОК |
| 10 | | Шуурхай штабыг идэвхжүүлэх | Ц+01:00-аас | Сумын Засаг даргын орлогч | СОК |
| 11 | | Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг үйл ажиллагаанд оруулах, хүч хэрэгслийг хуваарилах | Ц+01:00-аас | Сумын Засаг дарга | СОК |
| 12 | Иргэдийг үүссэн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах | Бүх нийтийн харилцаа холбоо, олон нийтийн сүлжээгээр | Ц+01:00-аас | СОК | Сумын Засаг дарга |
| 13 | Эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулах | Нурсан барилгаас нэрвэгдсдийг гаргах эрэн хайх, аврах | Ц+00:10-аас | Эрэн хайх, аврах бүлэг | СОК |
| 14 | Гал түймэр унтраах, тархалтыг зогсоох | Газар хөдлөлтөөс үүдэлтэй объектын гал түймрийг унтраах, дэлбэрэлтээс сэргийлэх | Ц+00:40-аас | ЕЗМА | СОК Гал унтраах сайн дурын хэсэг |
| 15 | Хэв журам сахиулах | Голомтын бүсэд хамгаалалт тогтоох, нийтийн аюулгүй байдлыг хангах | Ц+00:05-аас | Хэв журам сахиулах бүлэг | СОК |
| 16 | | Төв болон туслах замуудыг чөлөөлж, гадны хөдөлгөөнийг хязгаарлах | Ц+24:00-аас | | |
| 17 | | Улсын онц чухал объектуудыг хамгаалалтад авах, хяналтыг сайжруулах | Ц+01:00-аас | | |
| 18 | Нэрвэгдэгсдэд туслах, эмнэлгийн яаралтай тусламж | Аюулгүй талбайд иргэдийг бүртгэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлж, түр хоргодох газарт тээвэрлэх ажлыг зохион байгуулах | Ц+00:15-аас | ЭМТБ | СОК |
| 19 | Дэд бүтцийг сэргээх | Цахилгаан | Ц+01:30-аас | БЗӨБ, ЦТСС ХХК | СОК |
| 20 | | Дулаан, цэвэр бохирын шугам | Ц+06:00-аас | Дундговь ус ОНӨҮГ | СОК |
| 21 | | Харилцаа холбоо | Ц+12:00-аас | МХХА | СОК |
| 22 | Зам, гүүрний саадыг арилгах | Төв болон туслах замын нурангийг цэвэрлэх | Ц+03:00-аас | Хот тохижилт | СОК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | Хээрийн эмнэлэг дэлгэх | Нэрвэгдсэн иргэдийг хээрийн эмнэлэг рүү зөөвөрлөх | Тухай бүр | Хээрийн эмнэлэг дэлгэх хэсэг | ЕЗМА |
| 24 | | Бэртэж гэмтсэн иргэдийг анхны тусламж үзүүлж эрэмбэлэх | Тухай бүр | Анхны тусламжийн бүлэг | СОК |
| 25 | | Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх | Ц+12:00-аас | Анхны тусламжийн бүлэг | УЗХ |
| 26 | Дайчилгааны хангамж | Шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн тооцоог гаргаж нэмэгдүүлэх | Ц+01:00-аас | СЗДТГ-ын дарга | Сумын Засаг дарга |
| 27 | | Дайчилгаагаар ажиллаж буй техникүүдийг шатахуун, хүмүүсийг хоол хүнсээр хангах | Ц+24:00-дуустал | Хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах бүлэг | СОК |
| 28 | Хорогдох байраар хангах | Гэр оронгүй болсон иргэдийг хүлээн авах бүртгэх, эрэмбэлэх | Ц+12:00-аас | Түр орон байраар хангах бүлэг | СОК |
| 29 | Нүүлгэн шилжүүлэх | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг идэвхжүүлэх | Ц+02:00-аас | Нүүлгэн шилжүүлэх бүлэг | СОК |
| 30 | Нийгмийн халамж, хамгаалал | Эмзэг бүлгийн иргэдийг бүртгэж, тусгайлан тусламж үзүүлэх | Ц+06:00-аас | Халамжийн мэргэжилтэн | СОК |
| 31 | Тандалтын бүлэг ажиллуулах | Барилга байгууламжийн нуралтаас урьдчилан сэргийлэх | Ц+12:00-аас | Газрын даамал | СОК |
| 33 | | Хүний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | Ц+12:00-аас | ЭМТ | СОК |
| 34 | Нөхцөл байдлыг дахин үнэлэх | Биетээр тандалт хийж мэдээлэл цуглуулах | Ц+00:30-аас | ЕЗМА | СОК |
| 35 | Ар тал хангалт | Хоол, хүнсний хангалт | Ц+02:00-аас | Хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах бүлэг | СОК |
| 36 | | Шатахууны хангалт | Тухай бүр | | СОК |
| 37 | | Хувцас хэрэгслийн хангалт | Тухай бүр | | СОК |
| 38 | | Шаардлагатай техник хэрэгслийн хангалт | Тухай бүр | | СОК |
| 39 | | Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт | Тухай бүр | | СОК |
| 40 | Хүмүүнлэгийн тусламж зохицуулалт | Ирж буй хандив, тусламжийг хүлээн авах, бүртгэх, хуваарилах | Ц+24:00-аас | ЗДТГ-ын ажлын хэсэг | Сумын Засаг дарга |
| 41 | Нас барагсдыг таниулах | Буцалтгүй нэрвэгдэгсдийг хадгалах байрыг бэлтгэх | Ц+72:00-аас | ЕЗМА | СОК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 42 | | Буцалтгүй нэрвэгдэгсдийг зөөвөрлөх ажлыг зохион байгуулах | Ц+72:00-аас | ЕЗМА | СОК |
| 43 | | Цогцос хадгалах, зөөвөрлөх, ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгөх | Ц+72:00-аас | Нийтийн хэв журам хамгаалах хэсэг | СОК |
| 44 | Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах | Сумын хэмжээнд бохирдол үүссэн газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийх | Тухай бүр | СОК | Сумын Засаг дарга |
| 45 | Хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үнэлгээ | Гамшгийн дараах үнэлгээг хийх | Ц+72:00-аас | СОК | ОБГ |
| 46 | Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ | Санал оруулах | | | |





Үерийн эрсдэлийн аюулын түвшин тухайн сумын нутаг дэвсгэрийн 3317.1 талбай нь **Маш бага** түвшинд, 34.3 км2 нь Дунд түвшинд байна.

### 5.4 Үерийн хариу арга хэмжээ

| д/д | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран ажиллах, удирдан зохион байгуулах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аврах ажиллагааны дуудлага хүлээн авах | Нутгийн захиргааны болон аж ахуй нэгж, иргэдтэй холбогдож ослын голомтын байршил, нөхцөл байдал, газар зүй, цаг агаарын мэдээлэл авах | Ц+00:05-аас | ЕЗМА-ийн дарга | СОК |
| 2 | Мэдээллийн үнэн бодитой дамжуулах | Сумын Засаг даргад дуудлагын талаар мэдээлэл өгнө | Ц+00:02-аас | ЕЗМА-ийн дарга | СОК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Зарлан мэдээллэх дохиогоор ажиллуулах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхжүүлэх | Ц+00:10-аас | ЕЗМА-ийн дарга | СОК |
| 4 | Аврах ажиллагааны дуудлагаар ажиллах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхжүүлэх | Ц+01:00-аас | ЕЗМА-ийн дарга | СОК |
| 5 | Нөхцөл байдлыг үнэлэх | Шаардлагатай мэдээллийг СОК-т мэдэгдэх | Ц+00:30-аас | ЕЗМА-ийн дарга | СОК |
| 6 | Эрэн хайх, аврах | Усанд боогдсон, урссан иргэдийг аврах, нүүлгэх | Ц+00:15 | Аврах бүлэг: | СОК |
| 7 | Инженерийн хамгаалалт | Сэтэрсэн далан, сувгийг шуудайтай элс, шороогоор бөглөх | Ц+00:30 | ЕЗМА | СОК |
| 8 | Эрчим хүч хязгаарлах | Хоёрдогч /гал түймэр, цахилгаанд цохиулах гэх мэт/ аюулаас сэргийлж цахилгааны эх үүсвэрийг салгуулах | Ц+00:10 | Эрчим хүчний алба | АОК<br>СОК |
| 9 | Ус соруулах | Усанд автсан барилга, байгууламжийн усыг соруулах | Ц+01:00 | Инженерийн бүлэг: | СОК |
| 10 | Нүүлгэн шилжүүлэлт | Нэрвэгдэгсдийг түр оргонох байранд /Соёлын төв, ЕБС-ийн биеийн тамирын заал/ хүргэх | Ц+01:30 | ЕЗМА | СОК |
| 11 | Хэв журам сахиулах | Үерт автсан бусийн зам гарцыг хаах, хөдөлгөөнийг зохицуулах | Ц+00:20 | Хэв журам сахиулах бүлэг | СОК |
| 12 | Анхны тусламж | Гэмтсэн, даарч хөрсөн иргэдэд тусламж үзүүлэх | Тухай бүр | Эрүүл мэндийн тусламж үзүүлэх бүлэг | СОК |
| 13 | Ус, хүнсний хангамж | Түр байранд байгаа иргэдэд тусламж үзүүлэх /хоол, хувцас, бусад/ | Ц+03:00 | Хангамжийн бүлэг | СОК |
| 14 | Мэдээлэх | Аймгийн ШШ-т нөхцөл байдлыг тогтмол мэдээлэх | 2 цаг тутам | СШШ | СОК |
| 15 | Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ | Санал оруулах | | | |

**ЗАГВАР**





**5.6 Хүчтэй салхи, шуурганы үед авах хариу арга хэмжээ**

| № | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран ажиллах, удирдан зохион байгуулах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Урьдчилан сэргийлэх мэдээ | Цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээг малчид, иргэдэд бүх сувгаар хүргэх | Ц-06:00 (Шуурганаас өмнө) | Ус, цаг уурын өртөө | СОК |
| 2 | Хөдөлгөөн хязгаарлах | Сумын төвөөс гарах болон орох чиглэлийн авто замын хөдөлгөөнийг зохицуулах, орон нутгийн автозамыг шаардлагатай бол хаах саналыг АОК-ын даргад танилцуулах | Ц+00:10 | Нийтийн хэв журам хамгаалах хэсэг | СОК |
| 3 | Эрэн хайх, аврах | Шуурганд төөрсөн, сураггүй болсон малчид, иргэдийг хайх, цасанд боогдсон техник хэрэгслийг татан гаргах | Ц+00:30 | Эрэн хайх, аврах бүлэг | СОК |
| 4 | Зам даваа нээх | Хүйтний улиралд цасанд боогдсон төв болон туслах замуудыг цэвэрлэж, зорчих хөдөлгөөнийг нээх | Ц+02:00 | Зам, гүүр засварын бүлэг | СОК |
| 5 | Эрчим хүчний аюулгүй байдал | Салхинаас үүдэлтэй шугам тасрах, тулгуур унахаас сэргийлж хяналт тавих, засварлах | Ц+01:00 | Цахилгаан сүлжээний засварын бүлэг | СОК |
| 6 | Түр орогнох байр | Замд саатсан иргэдийг түр орогнох байр (Сургууль, Соёлын төв)-аар хангах | Ц+01:30 | Ерөнхий боловсролын сургуулийн захирал | СОК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Эмнэлгийн яаралтай тусламж | Осгосон, хөлдсөн иргэдэд анхны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргэх | Тухай бүр | Сумын ЭМТ | 4 эмч, сувилагч, түргэний тэрэг 1 |
| 8 | Дээд шатанд мэдээлэх | Аймгийн ОБГ болон аймгийн ШШ-т нөхцөл байдлыг тогтмол (2 цаг тутам) мэдээлэх | 2 цаг тутам | Шуурхай штаб | 2 ажилтан, холбооны хэрэгсэл |
| 9 | Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ | Санал оруулах | | | |

**5.7 Зудын үед авах хариу арга хэмжээ**

| № | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах нэгж | Хүч хэрэгсэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Өвөлжилтийн тандалт | Цаг үеийн нөхцөл байдлын мэдээ цуглуулах | Тухай бүр | СЗДТГ, ХАА тасаг | 4 хүн, машин 1 |
| 2 | | Багуудын цасны зузаан, бэлчээрийн нөөцийг 7 хоног тутамд үнэлэх | Тухай бүр | Цаг уурын өртөө | СОК |
| 3 | Судалгаа гаргах | Зудын эрсдэлд өртсөн малчин өрхийн судалгаа гаргах | Тухай бүр | Хөдөө аж ахуйн тасаг | СОК |
| 4 | Шийдвэр гаргах | Сумын онцгой комисс хуралдуулж, эрсдэлд өртсөн малчин өрхөүүдэд өвс, тэжээлийг хуваарилах тухай захирамж гаргах | Тухай бүр | Засаг даргын Тамгын газрын дарга | СОК |
| 5 | Отор нүүдлийн зохицуулалт | Хөрш сумдтай гэрээ байгуулж, оторлох нутаг, тууврын замыг тохирох | Ц+48:00 | ХАА тасаг, Багийн Засаг дарга | 3 ажилтан |
| 6 | Сумын аюулгүйн нөөц | Сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг малчдад хуваарилах | Тухай бүр | Хөдөө аж ахуйн тасаг | СОК |
| 7 | Тээврийн хэрэгслийн бэлэн байдал | Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг хүргэх, хаагдсан зам даваа нээх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Тухай бүр | Засаг даргын Тамгын газрын дарга | СОК |
| 8 | Эрэн хайх, аврах | Шуурганд төөрсөн малчин, иргэдийг хайх, цасанд суусан техник хэрэгслийг татан гаргах | Ц+00:30 | Эрэн хайх, аврах бүлэг | 15 хүн, Зил-131, ковш 1 |
| 9 | Зам даваа нээх | Цасанд боогдсон малчин өрхийн замыг нээх | Ц+02:00 | СОК | 6 хүн, ковш 1, тээврийн хэрэгсэл-1 |
| 10 | Өвс, тэжээлийн хуваарилалт | Сумын аюулгүй нөөцийг нэн эрсдэлтэй өрхүүдэд хүргэх ажлыг зохион байгуулах | Ц+24:00 | СОК | 8 хүн, ачааны машин 2 |
| 11 | Эмнэлгийн явуулын тусламж | Өвөлжөөндөө боогдсон малчдад эм тариа, эрүүл мэндийн тусламж үзүүлэх | Тухай бүр | СЭМТ | 3 эмч, сувилагч, Түргэний тэрэг 1 |
| 12 | | Отрын бүс нутагт байгаа малчин өрхөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх | | | |
| 13 | Малын эрүүл мэндийн хяналт | Тарга хүч алдсан малд витаминжуулалт, эрдэс тэжээлийн дэмжлэг үзүүлэх | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг | 2 мэргэжилтэн, тээврийн хэрэгсэл-1 |
| 14 | Тэжээлийн нэмэлт нөөц | Аймгийн онцгой комисст шаардлагатай өвс, тэжээлийн судалгаа гаргаж, албан бичиг хүргүүлэх | Тухай бүр | СОК | АОК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | | Аймгийн болон Улсын нөөцөөс тэжээл татан авах, хөнгөлөлттэй үнээр малчдад олгох | Тухай бүр | Хөдөө аж ахуйн тасаг | СОК |
| 16 | Хүмүүнлэгийн тусламж | Ирж буй хандив, тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах ажлыг тус төлөвлөгөөний 9 дүгээр бүлэгт заасны дагуу хийж хэрэгжүүлнэ. | Тухай | Хөдөө аж ахуйн тасаг | СОК |
| 17 | Мэдээлэл, зөвлөгөө | Цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээг малчдад хүргэх | Тухай бүр | Цаг уурын өртөө | СОК |
| 18 | Тайлагнах | Зудын эрсдэлт өртсөн айл өрхийн өвс тэжээлийн нөөц хүргэсэн талаарх тайлан мэдээ гаргах | Тухай бүр | СОК | АОК |
| 19 | мэдээлэх | Аймгийн ОБГ болон аймгийн ШШ-т хүргүүлэх | Тухай бүр | Шуурхай штаб | СОК |
| 20 | Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ | Санал оруулах | | | |

**5.11 Мал, амьтны гоц халдварт өвчний үед авах хариу арга хэмжээ**

Сумын Засаг даргын 20....... оны А/......
дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт

## ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

1. Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, холбогдох хүн, хүч хэрэгслийг татан оролцуулах, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, аймгийн Онцгой комиссыг шуурхай мэдээ, мэдээллээр хангах, тулгамдсан асуудлыг танилцуулан шийдвэрлүүлэх, ,

### Хоёр. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Штабын бүрэлдэхүүн 08:30-18:00 цаг хүртэл ажиллах бөгөөд 18:00 цагаас дараагийн өдрийн өглөөний 09.:00 цаг хүртэл мэдээллийн ажилтан мэдээ мэдээллийг нэгтгэн танилцуулах;

2.2. Шаардлагатай тохиолдолд штабын даргын шийдвэрээр Шуурхай штабыг ажлын тусгай горимоор (уртасгасан цагаар) ажиллуулах;

2.3. Штаб нь гамшиг, аюулт үзэгдэл, томоохон хэмжээний ослын нөхцөл байдалтай уялдуулан гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сумын Онцгой комиссын үйл ажиллагааг зохицуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах;

2.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

2.5. Үүссэн нөхцөл байдалд нутгийн захиргааны байгууллага, бусад байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөө, удирдлагын баримт бичгийг боловсруулж, тодотгох;

2.6. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд холбогдох газар, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аймаг, сумдаас хүн хүч, техник хэрэгсэл татан оролцуулах, хуваарилах;

2.7. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалын судалгааг гаргах, дайчлах, бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

2.8. Үүссэн нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийх, хариу арга хэмжээг төлөвлөх;

2.9. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн хандив тусламжийг хүлээн авах, тараах, зохицуулах;

2.10. Нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг нэгтгэн аймгийн Онцгой комисст танилцуулах;

2.11. Иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагыг гамшиг аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хариу арга хэмжээний тухай мэдээ, мэдээллээр хангах;

2.12. Шаардлагатай тохиолдолд Шуурхай штабын гишүүдийг гамшгийн голомтод томилон ажиллуулж, удирдлагаар хангуулах;

2.13. Үүссэн нөхцөл байдалд газар дээр нь очиж ажиллах, шуурхай албаны автомашинаар хангуулах;

2.14. Шуурхай штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа ажилтан, алба хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн ажилтанд нэмэгдэл хөлс, цалин, урамшуулал, гамшгийн голомтод ажилласан томилолт олгох асуудлыг шийдвэрлүүлэх;

❖

Сумын Засаг даргын 20....... оны А/......
дүгээр захирамжийн гуравдугаар хавсралт

## СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ

## ШТАБЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, холбогдох газар, хэлтсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах сумын Онцгой комиссын Шуурхай штаб (цаашид "Шуурхай штаб" гэх)-ын үйл ажиллагааг зохицуулах, эрх, үүргийг тогтооход оршино.

1.2. Шуурхай штаб нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Нөөцийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын Онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллана.

1.3.Сумын Онцгой комиссын Шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг энэхүү журамд нийцүүлэн сумын Онцгой комиссын дарга батална.

1.4.Шуурхай штаб нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа сумын Онцгой комиссын Шуурхай штабын нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, сумын Засаг даргын орлогчийн тэмдэг ашиглана.

### Хоёр. Шуурхай штабын удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1.Сумын Онцгой комиссын дарга Шуурхай штабыг бодлого, стратегийн удирдлагаар хангана.

2.2.Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг штабын дарга удирдан зохион байгуулж, сумын Онцгой комиссын дарга хяналт тавина.

2.3.Шуурхай штаб нь сумын Онцгой комиссын даргын баталсан ажлын байранд үйл ажиллагаа явуулах бөгөөд ажлын цагийн хуваарийг шуурхай штабын дарга батална.

2.4.Шуурхай штаб нь аймгийн Онцгой комиссын үйл ажиллагаатай ажлаа уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг авч ажиллана.

2.5.Шуурхай штабын бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах мэргэжлийн анги бүлэг, төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшний албан хаагч нарыг ажиллуулна.

2.6.Шуурхай штаб нь дарга, орлогч, нарийн бичиг, ажиллагаа зохицуулалтын, төлөвлөлтийн, статистик, судалгаа, дүн шинжилгээний, санхүү, нөөц хангалтын баг, , мэдээлийн технологи, харилцаа холбоо, мэдээллийн баг, аюулгүй байдал хариуцсан ажилтан(цаашид "Шуурхай штабын багууд гэх")-аас бүрдэнэ.

2.7.Шуурхай штабын бүрэлдэхүүн эрсдэлийн үнэлгээг шаардлага гарсан тухай бүр хийж, бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж болно.

2.8.Хариу арга хэмжээг зохион байгуулах багууд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.8.1. Ажиллагаа-зохицуулалтын баг:

- Төлөвлөлтийг хэрэгжүүлэх,

- Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл оруулах, дайчлах, хүн хүч хэрэгслийн судалгаа гаргах,

- Иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг зохион байгуулах,

2.8.2. Төлөвлөлтийн баг:

- Эрсдэл, нөхцөл байдлын үнэлгээ хийх,

- Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хариу арга хэмжээ авах төлөвлөлтийг боловсруулах,

- Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйн зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хангуулах,

- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, харилцан ажиллагааг зохион байгуулах,

2.8.3. Статистик, судалгаа, дүн шинжилгээний баг:

- Холбогдох статистик тоон мэдээллийг цуглуулах,

- Бүх төрлийн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх,

- Мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ үнэлгээ хийх,

2.8.4. Санхүү, нөөц хангалтын баг

- Холбогдох санхүүгийн тооцоог гаргах,

- Санхүүгийн холбогдолтой уйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, тооцох,

- Баримт бичиг хөтлөлт, хурал зохион байгуулах,

- Өргөдөл, гомдол, бичиг хэрэг, тайлан, архивын үйл ажиллагаа

- Бараа материал, өвс тэжээл нөөцийг гаргах, хуваарилах, нөөц бүрдүүлэх

- Хүнс, бараа, материалын нөөцийн бүртгэл, судалгаа гаргах,

2.8.5. Аюулгүй байдал хариуцсан ажилтан:

- Шуурхай штабын үйл ажиллагаа, ажилтан, алба хаагчдын аюулгүй байдал, баримт бичгийн нууцлал, хадгалалт, хамгаалалтыг хангах,

2.8.6. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, мэдээллийн баг:

- Шуурхай штабын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, ашиглах,

- Холбоо, зарлан мэдээллийн ажлыг зохион байгуулах,

2.9. Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан шийдвэр, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байна.

**Гурав. Шуурхай штаб, штабын дарга,**

**орлогчийн эрх, үүрэг**

**3.1.Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.1.1.Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;

3.1.2. Гамшиг, цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг үүсэх эрсдэл, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөж зохион байгуулах;

3.1.3.Шаардлагатай бараа материал, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний нөөцийн судалгааг гаргах, зохицуулах;

3.1.4. Аймгийн онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, сумын Онцгой комиссын үйл ажиллагааг уялдуулах, мэдээ, мэдээллийг цахим технологийн түвшинд шуурхай солилцох;

3.1.5.Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх арга хэмжээг хуулийн хугацаанд шуурхай зохион байгуулах;

3.1.6.Аймгийн Онцгой комисс, холбогдох байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох;

3.1.7.Шуурхай штабын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх.

**3.2.Шуурхай штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.2.1. Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтаар хангах, холбогдох түр журам, заавар батлах;

3.2.2. Шуурхай штабын багуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гүйцэтгэлд хяналт тавих;

3.2.3. Шуурхай штабын бүрэлдэхүүнд үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах, хяналт тавих;

3.2.4. Шуурхай штабын үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг сар тутам аймгийн онцгой комисст танилцуулах;

3.2.5. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр аймгийн Онцгой комисст тайлагнах;

3.2.6. Аймгийн Онцгой комиссын дарга, орлогч дарга, гишүүд болон холбогдох албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах;

3.2.7. Хоногийн нөхцөл байдлын мэдээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт өдөр тутам танилцуулах;

3.2.8. Хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч Шуурхай штабын бүрэлдэхүүний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ээлжийн зохион байгуулалтад оруулах, ажлын цагийн зохицуулалт хийх, шаардлагатай бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах.

3.2.9. Бусад

**3.3.Шуурхай штабын орлогч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.3.1. Шуурхай штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, шуурхай штабын багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, өдөр тутам хяналт тавих;

3.3.2. Шуурхай штабын багуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар шуурхай штабын даргыг мэдээллээр хангах;

3.3.3.Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Шуурхай штабын багуудын тавьсан санал, хүсэлт, шийдвэрлэх асуудлыг Шуурхай штабын даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.3.4.Шуурхай штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил, амралтын цагийг зохицуулах, эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах;

3.3.5.Сумын Онцгой комиссын тогтоол, шийдвэрийн төсөл, Шуурхай штабын тайлан болон олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг хянаж, шуурхай штабын даргад хүргүүлэх;"

3.1.6. Сумын Онцгой комисс, иргэд, олон нийтийг үүссэн нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээ, мэдээллээр хангах;

3.3.7. Шуурхай штабын бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, ажилласан цагийн тооцоо, ажил үүргийн гүйцэтгэлтэд хяналт тавих.

3.3.8. Бусад

**3.4.Нарийн бичиг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

3.4.1. Шуурхай штабын дарга, орлогч нарт дотоод ажлын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллах;

3.4.2. Аймаг, сумдын Шуурхай штабуудтай харилцан ажиллах, мэдээлэл солилцох;

3.4.3. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулах, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.4.4. Шуурхай штабын хоногийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэх;

3.4.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, холбогдох багуудад хуваарилах, шийдвэрлэлтийн бүртгэл хөтлөх, эзэн холбогдогчид эргэж мэдэгдэх;

3.4.6. Шуурхай штабын багуудын тайлан, мэдээг өдөр бүр авч нэгтгэх;

3.4.7. Аймгийн Онцгой комиссын Ажлын албанд шуурхай штабын тайлан мэдээг нэгтгэж хүргэх.

3.4.8. Штабын үйл ажиллагааг баримтжуулах, хариу арга хэмжээний багуудаас гарсан тайлан мэдээ, судалгаа, баримт, материалыг архивлах;

**3.7. Хэвлэл, мэдээллийн хэсэг дараах үүргийг хэрэгжүүлнэ:**

3.7.1.Сумын онцгой комисс, Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх;

3.7.2.Бэлтгэсэн мэдээ, мэдээллийн төслийг Шуурхай штабын орлогчид танилцуулж, үүрэг, чиглэл авах;

3.7.3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд залруулга хийх;

3.7.4.Шуурхай штабын хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулах;

3.7.5. Нөхцөл байдалтай холбогдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах;

**Дөрөв. Шуурхай штабын багуудын чиг үүрэг**

**4.1.Шуурхай штабын багуудын ахлагч дараах үүргийг хэрэгжүүлнэ:**

4.1.1.Багийн үйл ажиллагааг сараар төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, гүйцэтгэлийг Шуурхай штабын даргад тайлагнах;

4.1.2.Багийн үйл ажиллагааг өдөр тутам удирдан зохион байгуулах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, заавар, зөвлөмж өгөх;

4.1.3.Багийн тогтвортой ажиллагааг хангах, гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын хариуцлага, дэг журмыг сахиулах;

4.1.4.Багийн гишүүдийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах;

4.1.5.Багийн үйл ажиллагааны талаар Шуурхай штабын дарга, орлогчийг мэдээ, мэдээллээр тогтмол хангах;

4.1.6.Шуурхай штабын даргын өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрийг хэрэгжүүлж, биелэлтийг хангах, өдөр тутам авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг заасан хугацаанд Шуурхай штабын даргад танилцуулах;

4.1.7.Бусад багуудтай мэдээ, мэдээлэл солилцох, харилцан ажиллагааг хангах, дэмжлэг үзүүлэх.

**4.2. Ажиллагаа зохицуулалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.2.1. Үүссэн нөхцөл байдлыг тогтоох, мэдээлэл цуглуулах, хариу арга хэмжээг зохион байгуулах,

4.2.2. Хариу арга хэмжээний төлөвлөлтийг хэрэгжүүлэх, үүссэн нөхцөл байдлыг байр зүйн зурагт оруулах, хөтлөх,

4.2.3. Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл дайчлах, хуваарилах,

4.2.4. Хүн хүч хэрэгслийн судалгаа гаргах,

4.2.5. Олон улсын тусламжийн байгууллага болон иргэн, хуулийн этгээд, гадаад улс орноос ирүүлж байгаа тусламжийн бараа материалыг шийдвэрлэх,

4.2.6.Байгууллагуудын харилцан ажиллагааг зохион байгуулах, уялдуулах, мэдээ мэдээлэл солилцох,

4.2.7. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, холбогдох газар, хэлтсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, харилцан ажиллагааг зохион байгуулах,

**4.3. Төлөвлөлтийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.3.1. Үүссэн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах төлөвлөлтийг боловсруулах,

4.3.2. Эрсдэл, нөхцөл байдлын үнэлгээ хийх,

4.3.3. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хариу арга хэмжээ авах төлөвлөлтийг боловсруулах,

4.3.4. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйн зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хангуулах,

4.3.5. Гамшиг, цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр журам, заавар, төлөвлөгөөний төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн боловсруулах;

4.3.6. Хариу арга хэмжээний багуудын нэгдсэн тайланд хийсэн дүн шинжилгээг үндэслэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөх;

4.3.7. Шуурхай штабын багуудын сарын ажлын төлөвлөгөөг нэгтгэн шуурхай штабын сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах;

4.3.8. Хариу арга хэмжээний багуудын саналыг үндэслэн сургалтын хэрэгцээг тодорхойлж төлөвлөх;

**4.4. Статистик, судалгаа, дүн шинжилгээний баг:**

4.4.1. Холбогдох статистик тоон мэдээллийг бүрдүүлэх, мэдээллээр Шуурхай штабын дарга, багуудыг хангах,

4.4.2. Бүх төрлийн мэдээ мэдээлэл, судалгааг бүрдүүлэх холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,

4.4.3. Шуурхай штабын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийх,

4.4.4. Эмзэг бүлгийн иргэдийн судалгаа гаргах.

**4.5. Санхүү, нөөц, хангалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.5.1. Шаардлагатай бараа материал, өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, мэдээллээр Шуурхай штабын дарга, багуудыг хангах,

4.5.2. Хүнс, бараа, материалын нөөцийн бүртгэл, судалгаа гаргах,

4.5.3. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа зохион байгуулах,

4.5.4. Хариу арга хэмжээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, хэрэгцээг тодорхойлох, нөөцийн зураглал гаргах;

4.5.5. Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг тооцох, ажиллах заавар, журмаар хангах, сургалтад хамруулах, хяналт тавих;

4.5.6. Хүнсний нөөцийн судалгааг гаргах, тухай бүр тодотгох;

4.5.7. Ар тал, хангалтын /тээврийн хэрэгсэл, харилцаа холбоо, ус, дулаан хувцас, байр, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шатах тослох материал, хоол хүнсний хангамж, эмнэлгийн тусламж, санхүү/ талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэх, тодотгох;

4.5.8.Гамшгаас хамгаалах албадын хүч хэрэгслийн нөөцийн судалгаа гаргах, тодотгох;

4.5.9. Хүн амд шаардлагатай тохиолдолд хүнсний тусламж үзүүлэх төлөвлөлт, тооцоолол хийх, зохион байгуулах.

4.5.10. Шуурхай штабын бүрэлдэхүүний ажилласан өдөр, цагийн тооцоог гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.5.11. Шуурхай штабын үйл ажиллагааны зардал, төлбөр тооцоог шийдвэрлэх, зохион байгуулах;

4.5.12. Шуурхай штабын бүрэлдэхүүний хоол, унаа, томилолтын асуудлыг

4.5.13. Хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх;

4.5.14. Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, бичиг хэрэг, эд зүйлс, техник тоног төхөөрөмжөөр хангах санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх.

## 4.6. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, мэдээллийн баг

**дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.6.1.Шуурхай штабын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ болон техник хангамж, интернэт, тусгай сүлжээ, файл серверийн хэвийн үйл ажиллагааг хангах, тэдгээрийн хэрэглэгчийн цахим мэдээлэлд хяналт тавих;

4.6.2. Төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн системүүдийн уялдаа холбоог хангах, мэдээллийг анхдагч эх үүсвэрээс авах, мэдээллийн нэгдсэн урсгалыг бий болгох;

4.6.3. Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн системүүдийн хооронд мэдээллийг шуурхай солилцох боломжийг олгох шийдэл боловсруулах;

4.6.4. Нөхцөл байдлын талаарх орон зайн мэдээллийг бүрдүүлж, холбогдох мэдээллийн сангуудаас цахим хэлбэрээр татан төвлөрүүлж, дүн шинжилгээ хийх, үр дүн. зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;

**Тав. Бусад зүйл**

5.1. Штабын бүрэлдэхүүн нь төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

5.2. Штаб нь ажлын тусгай горимоор буюу уртасгасан цагаар ажиллана.

5.3. Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн харьяалах байгууллагын удирдлагад тухайн ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгуулах асуудлыг Шуурхай штабын дарга шийдвэрлэнэ.

5.4.Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

--000--

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**САЙНЦАГААН СУМЫН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20......оны ......сарын .....ны өдөр № ..... Шархулсан

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 хэсэг, "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутагт 20.... оны .... дугаар сарын .....-ны өдөр тохиолдсон .... магнитудын газар хөдлөлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирч, барилга байгууламж нурж, их хэмжээний хохирол үүссэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг 20... оны ... дугаар сарын ...-.ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Үүссэн гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга /Д.Адилбиш/-д үүрэг болгосугай.

3. Аврах ажиллагааг явуулах, иргэдийг нүүн шилжүүлэх, шаардагдах техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах, ажиллахыг аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан /Ж.Түмэндэмбэрэл/-д даалгасугай.

4. Эмнэлгийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх хээрийн эмнэлгийг дэлгэн байрлуулах, эм, ороох боох, материалыг гаргаж, нөөцийг нэмэгдүүлэх, цогцос хадгалах байрыг бэлтгэх нас барагсдыг таниулах, оршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан /Э.Адьяасүрэн/-д даалгасугай.

5. Эвдэрч нурсан барилга байгууламжийн нурангийг зайлуулах, хоёрдогч хөнөөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, сэргээн босгох, нурж болзошгүй барилгыг тодорхойлохыг сэргээн босголтын асуудал хариуцсан ажилтан /Ц.Баттөмөр/-т даалгасугай.

6. Газар хөдлөлтийн тухай мэргэжлийн ангид яаралтай мэдээлэх, холбоо зарлан мэдээллийн болон эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах, сэргээн засварлах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан /А.Ариунжаргал/, мэдээлэл сурталчилгаа хариуцсан ажилтан /Ж.Өнөрсайхан/ нарт даалгасугай.

7. Нурангинд өртсөн барилга, байгууламжийн харуул хамгаалалтыг чангатгах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг зогсоох, сум доторх болон сумаас гарах, орох хөдөлгөөнийг бүрмөсөн хориглож ажиллахыг Хэв журмын асуудал хариуцсан ажилтан /Х.Батхүлэг/-д үүрэг болгосугай.

8. Мэргэжлийн ангиудын үйл ажиллагаанд шаардагдах хүн хүч, техник хэрэгсэл, орон байр, хүнс, шатахуун зэргээр хангах, орон байргүй болсон иргэдийг түр орон байраар хангаж ажиллахыг гамшгаас хамгаалах нөөц хангалт хариуцсан ажилтан /Х.Сүхбат/-д үүрэг болгосугай.

9. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын ажлыг уялдуулан зохицуулж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, аврах ажиллагааны явц байдал, дүнгийн талаар аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газрыг мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга /Д.Адилбиш/-д даалгасугай.

10.Энэ захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн ангийн орлогч дарга,сумын Засаг даргын орлогч /О.Чимэддорж/-д даалгасугай.

ДАРГА С.БАТ-ОРГИЛ

Загвар төлөвлөгөө

Төсөл

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**САЙНЦАГААН СУМЫН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20...оны ...сарын...ны өдөр №... Шархулсан

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын мал эмнэлэгийн ариун цэврийн төв лабораторийн 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн .. дугаар шинжилгээний дүгнэлт, сумын Онцгой комиссын 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн ...-д ... .вирусээр үүсгэгдсэн ..... өвчний шинж тэмдэг илэрсэн тул сумын төвийн нутаг дэвсгэрт 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. ..... өвчний голомтын бүс нутгийг хамгаалалтанд авч хээрийн штаб, ариутгал, халдваргүйжүүлэлтийн пост, суурин болон хөдөлгөөнт эргүүлүүдийг томилон ажиллуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга /Д.Адилбиш, Мэргэжлийн ангийн дарга /..........., Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /........./ ,багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Тус сумын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч буй орон нутгийн чанартай авто замын маршрутыг өөрчилж ...... чиглэлээр явуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан /Ё.Насан-Өлзий/, хэсгийн төлөөлөгч /........../ нарт даалгасугай.

4. ... өвчний голомтод ажиллах мэргэжлийн багийг шаардагдах техник, хэрэгсэл, бодис материал, хамгаалах хувцас, шатахуун, хоол хүнсээр хангах, эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллахыг нөөц хангалт хариуцсан ажилтан /Ц.Мөнхгэрэл/, Эрүүл мэндийн төвийн үйлчилгээ хариуцсан ажилтан /........../ нарт тус тус үүрэг болгосугай.

5.Өвчний голомтод байгаа иргэдийг дархлаажуулах, иргэдийн эрүүл мэндийн байдалд тандалт хийх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч /............./-д даалгасугай.

6. .... өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа, сэрэмжлүүлгийг бүх төрлийн хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг Сургалт сурталчилгаа бэлэн байдал хариуцсан ажилтан /.........../-д даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /............./-д үүрэг болгосугай.

ДАРГА С.БАТ-ОРГИЛ

Загвар төлөвлөгөө

Төсөл

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**САЙНЦАГААН СУМЫН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20..оны ...сарын ....өдөр №.... Шархулсан

Гамшгийн хор уршгийг арилгах тухай

Монгол улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутагт тохиолдсон хүчтэй цасан шуурганы улмаас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан сумын онцгой комисс, мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг 20.... оны .....дугаар сарын ....ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Цасан шуурганд төөрч уруудсан хүн, малыг эрэн хайх, аврах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга /Д.Адилбиш/, Мэргэжлийн ангийн дарга /.........../ нарт үүрэг болгосугай.

3. Цасанд хаагдсан даваа, зам гүүрийг чөлөөлөх, тээврийн хэрэгсэл хүрч очих боломжгүй айл өрх, малчдын судалгаа гаргаж, өвс тэжээл, хоол хүнс, дулаан хувцас олгох, шаардлагатай тохиолдолд айл өрхийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг сэргээн босгол хариуцсан ажилтан /Ц.Баттөмөр/, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Шуурганд гэмтсэн цахилгаан болон холбооны агаарын шугам сүлжээг сэргээх, засварлах ажлыг шуурхай зохион байгуулж, эрчим хүч, дулаан болон үүрэн телефоны найдвартай хэвийн ажиллагааг ханган ажиллахыг Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан /............./-д даалгасугай.

5. Хүчтэй цасан шуурганы аюулт үзэгдлийн талаарх цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд шуурхай хүргэх, шуурганы хор уршгийн талаар урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг сургалт сурталчилгаа бэлэн байдал хариуцсан ажилтан /..../-д үүрэг болгосугай

6. Байгалийн аюулт үзэгдэл хүчтэй цасан шуурганы улмаас учирсан хохирлыг дүн мэдээг нэгтгэн гаргаж, танилцуулж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга /Д.Адилбиш/-д даалгасугай,

7. Цасан болон шороон шуурганы хор уршгийг арилгахад шаардагдах зардлыг тооцон орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Санхүү албаны дарга/ /...../-д зөвшөөрсүгэй.

8 .Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /..... /-д даалгасугай.

ДАРГА С.БАТ-ОРГИЛ

### ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ХҮЧ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

| Д/д | Сумын нэр | МА-ийн Удирдах бүрэлдэхүүн | МА-ийн тоо | Машин механизм | | Багаж зэвсэглэмж | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суудлын | Ачааны | Нэр, төрөл | Тоо, хэмжээ |
| 1 | Сайнцагаан | 9 | 66 | 4 | 2 | -Гал унтраах багаж хэрэгсэл<br>-Мотопомп<br>-Майхан<br>-ОП-1<br>-Т-5 баг<br>-R 2 хошуувч<br>-Хээрийн хувцас \улиралын\<br>-Аранз<br>-Хүрз, хөрөө<br>-Жоотуу, лоом<br>-Тахлын хувцас<br>-Усны гутал<br>-Хамгаалалтын шил<br>-Аврах шат, олс<br>-Дамнуурга | Ком<br>1ш<br>2ш<br>15ш<br>80ш<br>25ш<br>66ш<br>52ш<br>25/5ш<br>5/5ш<br>15ш<br>7ш<br>7ш<br>1/100м<br>3ш |
| гэх мэт мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн судалгааг гаргана. | | | | | | | |

### 1.2 САЙН ДУРЫНХАН

| Д/д | Аж ахуйн нэгж, байгууллага | Мэргэжлийн анги, нөхөрлөл, бүлэг | Бүрэлдэхүүний тоо | Машин, механизм | | Багаж, зэвсэглэмж | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суудлын | Ачааны | Нэр, төрөл | Тоо, хэмжээ |
| 1 | Сайн дурын бүлэг | Бүлэг | 15 | 1 | 1 | -Аптек<br>-Хувцас хэрэглэл<br>-Цахилгаан эх үүсгүүр<br>-Майхан<br>-Нөхөрлөлийн иж бүрдлийн цүнх | Ком<br>15ш<br>1ш<br>1ш<br>2ш<br>15ш<br>Ком |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Гал унтраах багаж хэрэгсэл | |
| Гэх мэт хүн хүч хэрэгслийн судалгааг гаргана. | | | | | | | |

Загвар төлөвлөгөө

**<u>Дайчлан ажиллуулах техникийн судалгаа:</u>**

## ГАМШГИЙН ҮЕД ДАЙЧЛАН АЖИЛЛУУЛАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

1. Дайчлагдан ажиллах бүрэлдэхүүний судалгаа

| д/д | Овог нэр | Регистрийн дугаар | Нас | Хүйс | Мэргэжил | Холбогдох утасны дугаар | Яаралтай үед холбоо барих утасны дугаар | Оршин суух хаяг, утасны дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эрэн хайх аврах ажиллагаанд<br>(18 нас хүрсэн, ажил үүрэг гүйцэтгэх чадвартай байх ) | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх<br>(эмч, сувилагч, асрагч мэргэжилтэй, сургалтад хамрагдсан) | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дулааны жугам сүлжээ, цэвэр бохирын хоолойн эвдрэл гэмтлийг засварлах үйл ажиллагаанд<br>(сантехникч, энэ чиглэлээр ажиллаж байсан туршлагатай) | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Эрчим хүчээр хангах, цахилгааны шугам сүлжээ засварлах ажиллагаанд<br>(цахилгаанчин, ажиллаж байсан туршлагатай) | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Програм хангамж, байр зүйн зураг дээр ажиллах | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Холбоо зохион байгуулалтыг хангах чиглэлэээр | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Гэх мэт тусгай нарын мэргэжлүүдээр дайчлагдан ажиллах иргэний судалгааг гаргана. | | | | | | | | |
| | | | | | | | | |

2. Дайчлагдан ажиллах техник, механизмын судалгаа

| д/д | д/д | Төрөл | Автомашины загвар | Улсын дугаар | Үйлдвэрлэсэн он | Хариуцах эзэн | Холбогдоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| Автомашин | | | | | | | |
| 1 | 1 | Суудлын | | | | | |
| | 2 | | | | | | |
| 2 | 3 | Ачааны | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | | | | | | |
| 3 | 5 | Хүн тээвэрийн | | | | | |
| | 6 | | | | | | |
| 4 | 7 | Усны автоцестерн | | | | | |
| | 8 | | | | | | |
| 5 | 9 | Шатахууны автоцестерн | | | | | |
| | 10 | | | | | | |
| Механизм | | | | | | | |
| 1 | 1 | Дугуйт ачигч | | | | | |
| | 2 | | | | | | |
| 2 | 3 | Экскаватор | | | | | |
| | 4 | | | | | | |
| 3 | 5 | Автогрейдр | | | | | |
| | 6 | | | | | | |
| Гэх мэт дайчлагдан ажиллах техникийн судалгааг гаргана. | | | | | | | |

| Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа | | | | | |
|---|---|---|---|---|---|
| д/д | Багаж хэрэгслийн нэр | Зориулалт | Тоо ширхэг | Хариуцах эзэн | Холбоо барих |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |

| | Үл хөдлөх хөрөнгө, бусад | | | | |
|---|---|---|---|---|---|
| д/д | Үл хөдлөх хөрөнгийн нэр | Зориулалт | Хаяг байршил | Хариуцсан эзэн | Холбоо барих |
| | | | | | |

**"Тэвшийн уурхай" ХХК-н автотехник, тоног төхөөрөмжийн судалгаа**

10/1/2025

| № | Төрөл | Марк | Улсын дугаар |
|---|---|---|---|
| **ИЛ УУРХАЙН ТЕХНИКҮҮД** | | | |
| 1 | Экскаватор | | |
| 2 | Экскаватор | | |
| 3 | Авто ачигч | | |
| 4 | Авто ачигч | | |
| 5 | Авто ачигч | | |
| 6 | Бульдозер | | |
| 7 | Өөрөө буулгагч | | |
| 8 | Өөрөө буулгагч | | |
| 9 | Өөрөө буулгагч | | |
| 10 | Өөрөө буулгагч | | |
| 11 | Өөрөө буулгагч | | |
| 12 | Усны машин | | |
| 13 | Үйлчилгээний машин | | |
| 14 | Үйлчилгээний машин | | |
| 15 | Үйлчилгээний машин | | |
| 16 | Үйлчилгээний машин | | |
| БУСАД | | | |
| 1 | Сэрээт ачигч | | |
| 2 | Ачааны машин | | |
| 3 | Түлшний машин | | |
| 4 | Генератор /хотхон/ | | |
| 5 | Генератор /хотхон/ | | |
| 6 | Генератор /хотхон/ эвдэрхий | | |
| 7 | Генератор /үйлдвэр/ дизель станцын талбай | | |
| 8 | Генератор /үйлдвэр/ | | |
| 9 | Генератор /үйлдвэр/ | | |
| 10 | Генератор /үйлдвэр/ | | |
| 11 | Генератор /үйлдвэр/ | | |
| 12 | Генератор /худаг/ 2 дугаар худаг | | |
| 13 | Генератор /үйлдвэр/ | | |
| 14 | Генератор /үйлдвэр/ | | |
| 15 | Генератор /үйлдвэр/ | | |
| 16 | Генератор /үйлдвэр/ шинэ | | |
| 17 | Генератор /хотхон/ | | |
| 18 | Гэрэлт цамхаг /Уулын хэлтэс/ | | |
| 19 | Халаагуур пуужин | | |
| 20 | Халаагуур пуужин | | |
| 21 | Халаагуур пуужин | | |
| 22 | Халаагуур пуужин | | |

•

**ГАМШГААС ХАМГААЛАХ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТҮР ЦУГЛАРАХ АЮУЛГҮЙ БАЙРШЛЫН ЦЭГ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, СОЛБИЛЦОЛЫН ЦЭГ**

| Түр цугларах аюулгүй байршлын цэг талбайн байршил | Хэмжээ | Солбилцолын цэг |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |




 -Түр цугларах цэг

## ГАМШГИЙН ҮЕД ХҮН АМ, ЭД ХӨРӨНГИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЖ БАЙРШУУЛАХ ТҮР БАЙРЛАЛ

| № | Байрлалд очих замын маршрут | Боломжит тээврийн хэрэгслийн төрөл | Байр зүйн солбилцол | Байрлах газрын нэр | Ашиглах боломжтой орон байр | Усны эх булаг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сумын төвөөс хойд зүгт | Автомашин, ердийн хөсөг явган цуваагаар | | | байхгүй | Байгаа /сумын ногооны талбайн гүн өрмийн худаг / |

## АРАВ. СУМЫН НУТАГТ НИСДЭГ ТЭРЭГ БУУХ, ХӨӨРӨХ ТАЛБАЙН БАЙРЛАЛ

| № | Нисдэг тэрэг буух,хөөрөх талбайн байрлал | Байр зүйн солбилцол | Тайлбар |
|---|---|---|---|
| | | | |

## ТОВЧИЛСОН ҮГ

АОК – Аймгийн Онцгой комисс
АТҮТ-Автотээврийн үндэсний төв
АУГ-Ажиллагааны удирдлагын газар
ББХАҮМА-Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба
БХБА- Барилга хот байгуулалтын алба
ББ-Боловсролын байгууллага
ГТТГ-Гал түймэртэй тэмцэх газар
ГТУАА-Гал түймэр унтраах, аврах анги
ГХА – Гамшгаас хамгаалах алба
ГХМА – Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги
ГЭБОНЗ - Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл
ЗГЗҮМА- Зам гүүрний засвар үйлчилгээний мэргэжлийн анги
ЗД-Засаг дарга
ЗТА- Зам тээврийн алба
МБЦХА-Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба
МХХА-Мэдээлэл харилцаа холбооны алба
НЗБ-Нутгийн захиргаан байгууллага
НХМА-Нийгмийн хамгааллын мэргэжлийн анги
ОБГ-Онцгой байдлын газар
ОБЕГ-Онцгой байдлын ерөнхий газар

ОУБ- Олон улсын байгууллага
СДХ- Сайн дурын хэсэг
СЗДТГ-Сумын Засаг даргын тамгын газар
СОК-Сумын Онцгой комисс
ТЗЗҮМА-Төмөр замын засвар үйлчилгээний мэргэжлийн анги
ТХБХМА-Түр хоргодох байраар хангах мэргэжлийн анги
ТЦБХСБ- Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага
ТЭХА-Түлш эрчим хүчний алба
УЗХ-Улаан загалмайн хороо
УУА-Уул уурхайн алба
УЦУОШГ-Ус, цаг уур, орчны шинжилгээний газар
ХБИ-Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЖСА-Хэв журам сахиулах алба
ХХААА-Хүнс, хөдөө аж ахуйн алба
ХЦА-Хилийн цэргийн анги

ХБ-Хүмүүнлэгийн баг
ХЭМА-Хуулийн этгээдийн мэргэжлийн анги
ЦХМА-Цахилгаан хангамжийн мэргэжлийн анги
ШТС-Шатахуун түгээх станц
ШШГ- Шүүх шинжилгээний газар
ШШГГ-шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШ-Шуурхай штаб

ЭМА-Эрүүл мэндийн алба

ЭМБ- Эрүүл мэндийн байгууллага